



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 22 өдөр

Дугаар A/284

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн П.Цэцэгсүрэн нь ар гэрийн гачигдлаар Улаанбаатар хот явах болсон тул зардалд 500000 төгрөг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 500000 төгрөг (таван зуун мянга)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ